



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/46

Зуунмод

Бүс шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2 дахь, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, Иргэний нисэхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2023 оны 07 дугаар хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Төв аймгийн Сэргэлэн сумын Хөшгийн хөндийд байрлах Олон Улсын шинэ нисэх буудлын Аэродром орчмын аюулгүй бүс дэх “Онцгой хамгаалалтын А бүс”, “Тусгай хамгаалалтын Б бүс”, “Саадыг хязгаарлах гадаргуу-Ойртолын бүс”-ийн координатуудыг хавсралтад зааснаар газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсүгэй.

2. Олон Улсын шинэ нисэх буудлын “Аэродром орчмын аюулгүй бүс”-д газрын эрх олгох, аливаа барилга байгууламж барих, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохдоо Зам, Тээврийн Хөгжлийн сайдын 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн “Техникийн баримт бичиг батлах тухай А/131 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт”-ын техникийн баримт бичиг, 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/56 дугаар тушаалаар баталсан “Техникийн баримт бичигт өөрчлөлт оруулах тухай” өөрчлөлтийг мөрдөх, Аэродромын гэрчилгээ эзэмшигч нисэх буудал болон Иргэний нисэхийн ерөнхий газартай урьдчилан зөвшилцөж, нислэгийн аюулгүй байдлыг хангасан шийдвэр гаргаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал)-т даалгасугай.

3. Аэродром орчмын аюулгүй бүсийн тусгай хамгаалалттай газрын хил хязгаарыг шинэчлэн газар дээр нь тэмдэгжүүлж, тухайн бүс дэх газар ашиглалтад хяналт тавьж ажиллахыг “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Китанака Такэфуми)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/522 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР